

Боловсролын сайдын 2024 оны 12
дугаар сарын 04-ны өдрийн 4/206
дугаар тушаалын хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ
ШААРДЛАГА**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү шаардлагын зорилго нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан боловсролын байгууллагын үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт эдлүүлэхтэй холбоотой тавигдах шаардлага болон түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Албан татварын хөнгөлөлт эдлүүлэхдээ Татварын ерөнхий хуульд заасан хугацааг баримтална.
- 1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэх татвар төлөгч нь хөнгөлөлт тус бүрээр татварын цахим төлбөрийн баримтын системд холбогдох баримтыг эрх бүхий байгууллагын нотлох баримтад үндэслэн бүрдүүлж, тайлагнасан байна.
- 1.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 22.9-д заасны дагуу хөнгөлөлтийг олгохдоо дараах зарчмыг баримтална.
 - 1.4.1. нийгмийн хариуцлагад суурилсан, сайн дурын байх
 - 1.4.2. ил тод, нээлттэй байх
 - 1.4.3. баримт, нотолгоонд үндэслэсэн байх
 - 1.4.4. хүний хөгжлийг дэмжсэн байх
 - 1.4.5. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

**Хоёр. Татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд
тавих шаардлага**

- 2.1. Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд боловсролын салбарт оруулсан дараах хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг энэхүү шаардлагад хамруулж үзнэ.
 - 2.1.1. Сургалтын байгууллагын орчныг дэмжих хөрөнгө оруулалт:
 - 2.1.1.1. Гадна талбайн тохижилт
 - 2.1.1.2. Сургуулийн барилга байгууламж барих, өргөтгөх
 - 2.1.1.3. Цэцэрлэгийн барилга байгууламж барих, өргөтгөх
 - 2.1.1.4. Спорт заал барих, өргөтгөх
 - 2.1.1.5. Дотуур байр барих, өргөтгөх
 - 2.1.1.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын сургалтын байр болон дадлагын төвийн барилга байгууламж барих, өргөтгөх

- 2.1.1.7. Байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх
- 2.1.1.8. Сурагчийн ширээ, сандал
- 2.1.1.9. Дотуур байрны ор, тавилга, тохижилт
- 2.1.1.10. Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин
- 2.1.1.11. Тоглоом наадгай
- 2.1.1.12. Сургалтын хэрэглэгдэхүүн (дэвшилтэт шинэ тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, дижитал хэрэглэгдэхүүн, STEM (шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх) боловсролыг дэмжих, леги, робот болон бусад зохион бүтээх хэрэгсэл)
- 2.1.1.13. Цахим танхим, лаборатори, номын сан, дижитал сурах бичиг
- 2.1.1.14. Бусад сургалтын тоног төхөөрөмж (гал тогоо, компьютер, принтер, самбар гэх мэт)
- 2.1.1.15. Орчны эрүүл ахуйн стандартад нийцсэн ариун цэврийн өрөө, өрөөний тохижилт, сайжруулалт

2.1.2. Хүний хөгжил, сургалтыг дэмжих үйл ажиллагаа

- 2.1.2.1. Багш, ажилтны чадавх мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, хөтөлбөр
- 2.1.2.2. Сургалтын олон улсын стандарт, хөтөлбөр, системийг нэвтрүүлэх, менежментийн үйлчилгээ үзүүлэх
- 2.1.2.3. Багш, ажилтны дутагдлыг нөхөх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх (орон байраар хангах, нэмэлт цалин, урамшуулал олгох, эрүүл мэндийн үйлчилгээ болон даатгалд хамруулах)
- 2.1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх сургалт, хандив
- 2.1.2.5. Дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, энтрепренершилд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалт, үйлчилгээ
- 2.1.2.6. Сургууль завсардсан хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалт
- 2.1.2.7. Боловсролын сэтгэл зүйн хөтөлбөр
- 2.1.2.8. Иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих сургалт
- 2.1.2.9. Хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих (сүү болон бусад хөтөлбөр)

2.2. Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг Тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан санд хандивласан байх.

2.3. Их, дээд сургуульд судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэгт энэхүү нийтлэг шаардлагын 2.3.1, 2.3.2-д заасан шалгуурыг тавина.

2.3.1. Засгийн газрын 2023 оны 249 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт"-д нийцсэн байх;

2.3.2. Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-д нийцсэн байх;

2.4.Төрийн болон орон нутгийн өмчит боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хөрөнгө оруулалт тавигдах шаардлага:

2.4.1.Энэхүү нийтлэг шаардлагын 2.1-д заасан хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа нь эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох стандарт, техникийн зохицуулалт, норм дүрмийн шаардлагыг хангасан байна.

2.4.2. Аливаа хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмчид шилжсэн байна.

2.4.3.Хандив, тусламж нь Төсвийн тухай хуулийн 25.2.2, 25.4, 25.5 болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна.

2.4.4.Аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон хандив, тусламжид Төсвийн тухай хуулийн 25.3, 25.5-д заасан хязгаарлалтууд хамаарахгүй.

2.4.5.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.2, 5.3.10-д заасан сангийн үйл ажиллагааг дэмжсэн байх.

Гурав. Хяналт, баталгаажуулалт

3.1.Татварын албанаас татвар төлөгчийн хөнгөлөлтөд хамрагдсан татварын тайланг хүлээн авах, тайлан мэдээллийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг дараах хугацаанд талууд зохион байгуулна.

Тайлангийн хугацаа	Тайланг хүлээн авах	Тайланг Боловсролын яаманд хүргүүлэх	Тайланг баталгаажуулах
1-р улирал	4 дүгээр сарын 20-ны дотор	5 дугаар сарын 10-ны дотор	5 дугаар сарын 31-ний дотор
2-р улирал	7 дугаар сарын 20-ны дотор	8 дугаар сарын 10-ны дотор	8 дугаар сарын 31-ний дотор
3-р улирал	10 дугаар сарын 20-ны дотор	11 дүгээр сарын 10-ны дотор	11 дүгээр сарын 30-ны дотор
Жилийн эцсийн тайлан	Дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор	Дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор	Дараа оны 5 дугаар сарын 31-ний дотор

3.2.Боловсролын салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага нь орон нутгийн Засаг дарга болон орон нутгийн боловсролын хэлтэстэй гэрээ байгуулсан байна.

3.3.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр татварын хөнгөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна.

3.4 Ажлын хэсэг нотлох баримтыг бүрдүүлэн дүгнэлт гаргах бөгөөд ажлын хэсгийн дүгнэлтийг Татварын ерөнхий газарт хүргүүлнэ.

3.5.Дээрх нотлох баримтыг үндэслэн Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулна.

3.6.Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын урт хугацааны татварын хөнгөлөлтөд хамрагдах татвар төлөгчийн тайлант жилүүдийн зардлын дүн, төслийн гүйцэтгэлийг энэхүү нийтлэг шаардлагын 3.3-д заасан ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн баталгаажуулалт хийж, 3.1-д заасан хугацаанд Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.